



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/501

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 а, 29.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс Хүнс, хөдөө ахуйн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит IV хуралдааны II, 2017 оны ээлжит V хуралдааны 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнсний хууль эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах, хүнсний зориулалтын бус хуванцар савыг хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн газарт хоол, хүнсний савлагаанд хэрэглэхийг хориглох, хор уршгийн талаар нийтэд мэдээлэх, сэрэмжлүүлэх зорилгоор сурталчилгааны гарын авлага, тараах материал бэлтгэн хэвлүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т, үүрэг болгосугай.

2. Сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг I, гарын авлага, тараах материал, самбарын эх бэлтгэн хэвлүүлэх, сурталчилгааны зардалд шаардагдах зардлыг II, хавсралтаар тус тус баталсугай.


3. Сурталчилгааны гарын авлага тараах материалыг бэлтгэн хэвлүүлэхэд шаардагдах 2500000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг /Хүнсний зах, төв, үйлчилгээний газруудын нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, стандартын сав баглаа, боодлын зохистой худалдаа, хэрэглээний талаар хуулийн этгээд болон иргэдэд зөвлөмж, уриалга гаргах, мэдээллийн хэрэгслээр хүргэх, сурталчилах, хэрэглээ хэвшүүлсэн байх/ зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 07-ны өдрийн
80 дугаар захирамжийн II хавсралт



**СУРТАЛЧИЛГААНЫ ГАРЫН АВЛАГА, ТАРААХ МАТЕРИАЛ САМБАРЫН ЭХ БЭЛТГЭН
ХЭВЛҮҮЛЭХ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Шаардагдах зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төг/	Бүгд үнэ /сая.төг/	Тайлбар
Хэвлэлийн зардал						
1	Гарын авлага бэлтгэн хэвлүүлэх	ширхэг	1000	1.5	1500.0	
2	Жижиг плакат хэвлүүлэх	ширхэг	280	2.5	700.0	
Сурталчилгааны зардал						
1	Шторк бэлтгэн цацах			300.0	300.0	
	Нийт зардал				2500.0	